

Цуврал хичээл-5

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУВЬЦАА

ХУВЬЦАА ҮҮССЭН ТҮҮХЭЭС:

Хоол амтлагч хийдэг байсан шуудайнууд "хувьцаа" төрөхөд тусалсан гэвэл та үнэмших үү?

Үнэхээр перец хэмээх энэхүү хоол амтлагчийг наймаалдаг басан Амстердамын худалдаачид хувьцаа үүсэх эхлэлийг тавьсан юм. 16-р зууны сүүлч үеэр жил бүр 70 хүртэлх хөлөг онгоцонд тэдгээр "Хоол амтлагч хийдэг шуудайнууд"-ыг ачин Индонез руу илгээдэг байсан байна. Учир нь Индонезид перец ихээр ургадаг байжээ. Перечны наймаа нь ашигтай бизнес болтлоо хөгжиж маш олон компаниуд энэхүү наймаанд оролцох болсон байна. Тэдгээрээс хамгийн томууд нь 1602 онд "Дорнод энэтхэгийн худалдааны нэгдсэн компани" /vereinigten Ostindischen Handels-Kompanie/ VOC нэртэйгээр нэгджээ. Эхэндээ баян худалдаачид, муж, хотууд энэхүү бизнест хувь нийлүүлэх хэлбэрээр орсон байна. Нэгэн компанийн хувь эзэмших энэхүү шинэ санаа нь хувьцаа гэж нэрлэгдэх болжээ. VOC-ын хувьцаа эзэмшигчид өөрийн оруулсан хөрөнгөндөө 75 хүртэл хувийн ногдол ашиг авч байжээ. Хэдхэн арван жилийн дараа түүний үнэ цэнэ тав дахин өссөн байна.

VOC-ын хувьцааны /1606 он/ жинхэнэ эх хувь нь өнөөдөр Амстердамын биржид өлгөөтэй байдаг ажээ. Нидерландын VOC компани нь одоо ч хувьцаат компанийн үлгэр жишээ болсоор байна.

Хоёрдахь хувьцаат компани бол VOC-ын түүхтэй салшгүй холбоотой Английн <East-India company> юм. Уг компани аль 1600 онд байгуулагдсан боловч зөвхөн 1613 онд хувьцаат компани болсон аж. Англитай хийсэн дайн, удирдлагын алдаа, East-India компанийн /1613-1858/ өрсөлдөөн өсөөгүй зэрэг шалтгаанаас болж 1799 онд VOC компанийн түүх төгсжээ.

ХУВЬЦАА ГЭЖ ЮУ ВЭ?

Хөрөнгө оруулсан буюу хувь нийлүүлсэн болохыг гэрчилсэн үнэт цаасыг хувьцаа гэнэ. Анхдагч зах зээл дээр хувьцаат компани өөрийн хөрөнгө буюу дүрмийн сангаа үнэлээд тодорхой тооны хувьцааг гаргадаг. Ингэснээрээ уг компани өөрийн хувьцаа эзэмшигчтэй болдог. Үүнийг анхдагч тараалт буюу анхдагч гаргалт гэж нэрлэнэ. Үүнээс гадна хувьцаат компани санхүүгийн боломжоо нэмэгдүүлэх шинэ хөрөнгө оруулалт хийхийн тулд шинээр хувьцааг анхдагч зах зээл дээр гаргах үйл ажиллагааг хоёрдогч гаргалт гэж нэрлэдэг.

Хувьцаа эзэмшигч компанийн ашгаас ноогдол ашиг буюу дивидент авна. **Дивидент гэдэг** нь хувьцаа бүрд тооцож гаргасан ашиг юм. Энэ хэмжээ нь тухайн компанийн ашиг орлогоос хамаарна. Хувьцаа эзэмшигч дараах эрхүүдийг эдэлнэ.

Хувьцаат компанийн захирлын зөвлөлөөс хувьцаа эзэмшигчиддээ дивидент хуваарилах шийдвэр гаргасан тохиолдолд эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр ноогдол ашиг авах эрхтэй


–ХК-ны захирлын зөвлөлийг сонгоход санал өгөх гэх мэт компанийн үйл ажиллагааг удирдахад оролцох эрхтэй.

-ХК-аасаа санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл тогтмол авч байх эрхтэй.

-Хувьцаагаа худалдах, бэлэглэх эрхтэй.

Хувьцаа эзэмшигчдийн эрх нь тэд нарын эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээнээс хамаарна. Хувьцаа арилжаалах хоёрдогч зах зээл нь ханш тогтоолтын системтэй ба захиалгын системтэй гэсэн хоёр үндсэн төрлийнх байдаг. Ханш тогтоолтын системд үх зээл бий болгогч нар буюу трейдерүүдийн хувьцааг худалдан авах ба зарах үнийг тогтоодог. Хөрөнгө оруулах сонирхолтой хөрөнгө оруулагч нар брокеруудаар дамжуулан сонирхож буй хувьцааныхаа хамгийн ашигтай үнийг сонгож авна.

ХУВЬЦАА гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ гэж Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан байдаг. Жишээлбэл Та “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг эзэмшсэнээр тус компанийн хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч болж, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар олгогдсон хувьцаа эзэмшигчийн эрхийг эдэлнэ. Гэхдээ ямар төрлийн хувьцаа эзэмшиж байгаагаас хамааран таны эдлэх эрх харилцан адилгүй байна.



Компанийн хувьцаа нь энгийн болон давуу эрхийн гэсэн хоёр төрөлтэй байдаг бөгөөд эдлэх эрх нь ялгаатай байна. Бүх компани энгийн хувьцааг

заавал гаргах үүргийг хуулиар хүлээдэг бол давуу эрхийн хувьцааг өөрийн сонголтоор гаргаж болно. Төрөөс иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 536 ширхэг хувьцаа бол энгийн хувьцаа юм. Харин “Эрдэнэс МГЛ” ХХК-н 1 ширхэг хувьцаа олгохоор болсон нь давуу эрхийн хувьцаа юм.

ЭДГЭЭР ХУВЬЦААНЫ ҮНДСЭН ЯЛГААГ ДАРААХ ХҮСНЭГТЭД ХАРУУЛАВ.

ЭНГИЙН ХУВЬЦАА	ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА
Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар санал өгөх эрхтэй.	Зөвхөн давуу эрхийн хувьцаатай холбоотой асуудлаар санал өгөх эрхтэй.
Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг	Ногдол ашгийг тэргүүн ээлжинд,

төлсний дараа, компаниас ногдол ашиг хувиарлахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг авна.	тогтмол авна.
Компани татан буугдсны дараа эд хөрөнгийг худаалдаалснаас олсон орлогоос ногдох хувиа зээлдүүлэгч болон давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн дараагаар авдаг.	Компани татан буугдсны дараа эд хөрөнгийг худаалдаалснаас олсон орлогоос нэн тэргүүнд ногдох хувиа хүртэнэ.

Хувьцааны давуу тал:

- Ногдол ашиг авах
- Ханшийн өөрчлөлтөөс ашиг олох
- Саналын эрх эдэлж, компанийн удирдлага, шийдвэр гаргах үйл явцад оролцох
- Хөрвөх чадвар сайтай
- Инфляцид өртөхгүй

Хувьцааны сул тал:

Аливаа юм болгон хоёр талтай байдгийн адил хувьцаа эзэмших нь мөн л давуу болон сул талтай. Хувьцаанд хөрөнгө оруулах нь хадгаламжид мөнгөө хийх, бонд худалдаж авахаас илүү ашигтай боловч тэр хэрээрээ эрсдэл өндөртэй байдаг. Тухайлбал, аливаа компанийн хувьцааны ханш нэг тогтсон түвшинд байдаггүй, эдийн засаг, зах зээлийн мөн компанийн үйл ажиллагаа зэрэг гадаад дотоод олон хүчин зүйлээс хамааран хэлбэлзэж байдаг. Тэгэхээр өндөр үнээр худалдаж авсан хувьцаа маань ханшийн уналтад орох тохиолдол гарна. Цаашилбал компани дампуурах эрсдэл ч бий. Ер нь хувьцаанд хөрөнгө оруулагч нь банкны хадгаламж болон бондоос илүү өндөр ашиг олох зорилготой байдаг. Гэвч ашиг их бол эрсдэл их гэдэг зарчмын дагуу хувьцаа илүү ашиг олох боломжтой ч өндөр эрсдэлтэй тул та сонголтоо зөв хийх нь хамгаас чухал юм.

Хувьцааг хэрхэн худалдаж авдаг вэ?

Ихэнхи хүмүүс хувьцаа худалдан авах санхүүгийн чадвартай бөгөөд аль компанийн хувьцааг худалдаж авахаа мэдэж байгаа тохиолдолд брокерээр дамжуулан тухайн компанийн хувьцааг худалдан авдаг. Брокерууд нь ихэвчлэн брокерийн компанид ажилладаг бөгөөд хувьцааны арилжааны талаар мэдлэг, туршлагатай тусгай лицензтэй байх шаардлагыг хангасан байдаг. Брокерийн байгууллагыг хувьцааны супермаркеттэй адилтган үзэж болно. Брокер нь хөрөнгө оруулагч дэлхийн аль ч улсад бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгийн биржэд бүртгэлтэй компанийн хувьцааг хэдэн зуу, мянгаар нь худалдаж авахад нь тусладаг. Хөрөнгө оруулагч нь брокерт ямар компанийн хувьцааг хэдий хэмжээтэй авахаа хэлэх бөгөөд брокер тухайн хувьцааны одоогийн үнийг хөрөнгө оруулагчид танилцуулан хөрөнгө оруулагчийн зүгээс худалдан авах хувьцааны талаар цахим мэдээллийг хөрөнгийн бирж рүү

илгээдэг. Үүний дараа хөрөнгө оруулагч хувьцааны үнийн төлбөрийг брокерт төлөх бөгөөд уг төлбөр нь тухайн хувьцааг арилжагч талд төлбөр хийгдснээр хөрөнгө оруулагч нь хувьцааны гэрчилгээг хүлээн авч хувьцаа худалдан авах үйл ажиллагаа дуусгавар болдог. Брокер нь хувьцаа худалдан авах, арилжаалах үйлчилгээг үзүүлсний хөлсөнд дунджаар 2%-5%-ийн төлбөрийг авдаг. Хөрөнгө оруулагч нь мөнгөө хөрөнгө оруулалтын сан эсвэл санхүүгийн байгууллагад байрлуулж болно. Хөрөнгө оруулалтын сангийн менежер нь хөрөнгө оруулагчийн мөнгийг жилийн турш хувьцаа худалдан авах, зарахад зарцуулдаг бөгөөд хөрөнгө оруулагч нь сангийн үнийн дүнгийн өсөлт, бууралтын талаар тогтмол мэдээллийг хүлээн авч байдаг. Хөрөнгө оруулагч нь сангийн нэгээхэн хэсгийг өмчилдөг бөгөөд харин аль нэг тухайлсан компанийн хувьцааг эзэмших боломж байдаггүй.

Хувьцаагаар яаж ашиг олдог вэ?

Нээлттэй хувьцаат компани жишээ нь Айвенхоу Майнз компанийн хувьцааг худалдаж авч байгаа хүн хоёр байдлаар ашиг олж болно.

1. Компани ашиг олсон тохиолдолд тухайн ашгийн тодорхой хэсгийг хувьцаа эзэмшигч ноогдол ашиг хэлбэрээр хүртдэг. Компани хэдий хэмжээний ашиг орлого олсон, компанийн захирал хэдий хэмжээний мөнгийг шинээр тоног төхөөрөмж худалдан авах, бизнесийн үйл ажиллагаа өргөтгөхөд зориулан нөөцөнд хадгалахаас шалтгаалан ноогдол ашгийн дүн жил бүр адилгүй байдаг.
2. Компани ашиг олоогүй эсвэл ноогдол ашиг хувиарлах хэмжээний ашиг олоогүй тохиолдолд хувьцаа эзэмшигч нь тухайн хувьцааны анхлан худалдаж авсан үнэ өссөн тохиолдолд хувьцаагаа заран ашиг олж болох бөгөөд уг олсон ашгаа банкинд хадгалуулах, эсвэл өөр зүйлд хөрөнгө оруулах буюу жишээ нь өөр компанийн хувьцааг худалдан авах аль эсвэл хувцас, гар утас, телевизор худалдан авах зэрэгт зарцуулж болно. Ерөнхийдөө хөрөнгө оруулагч нар ирээдүйд ашигтай ажиллан хувьцааны үнэ нь өсөх компанид хөрөнгө оруулах хүсэлтэй байдаг. Хувьцаа худалдан авснаар олох ашиг, эрсдлийн тухай ойлголт Тухайн компанийн үйл ажиллагаа сайн явагдаж ирээдүйд их хэмжээний ашиг олох чадвартай мөн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь зах зээл дээр эрэлт хэрэгцээ их байгаа зэргийг харгалзан олон тооны хөрөнгө оруулагчид компанийн хувьцааг худалдаж авч байвал тухайн компанийн хувьцааны үнэ өсөх болно. Жишээ нь аль нэг уул уурхайн компани зэс, алт зэрэг томоохон чухал орд газрыг нээсэн, дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ өссөнөөс уг компанийн хувьцааны үнэ өсөх нь дамжиггүй. Харин хөрөнгийн бирж дээр компанийн хувьцааны эрэлт хэрэгцээ багасан хөрөнгө оруулагч нар хувьцаа худалдан авахгүй байвал хувьцааны үнэ анхлан авсан үнээс доошлон энэ үед хувьцааг зарах юм бол хөрөнгө оруулагч алдагдал хүлээх болно. Энд нэг зүйлийг анхаарахад компанийн хувьцаа жилээс жилд өсөх түүнчлэн компани тогтмол ноогдол ашгийг хувьцаа эзэмшигч нарт олгох ямар ч баталгаа байхгүй. Хөрөнгө оруулагч нь компанийн хувьцаа эзэмшигч болсноор тухайн компани ашиггүй ажиллах эрсдлийг хүлээн авах хэрэгтэй болдог. Энэ нь бизнес эрхлэгч бүхэн ашиг олохгүйтэй адил. Компанийн өмчийн нэгээхэн хэсгийг өмчлөгчийн хувьд хувьцаа эзэмшигч

нь компанийн эд хөрөнгөд нэхэмжлэл гаргаж болох боловч уг нэхэмжлэл нь компанид мөнгө зээлдэгчидийн нэхэмжлэлийг бодвол хүч султай байдаг. Хэрвээ компани дампуурлаа зарлах эсвэл өрөө барагдуулахын тулд өөрийн эд хөрөнгөө зарах тохиолдолд компани банк, бонд эзэмшигчдийн төлбөрийг барагдуулж дуусахыг хүртэл энгийн хувьцаа эзэмшигч нь ямар ч төлбөр авдаггүй. Үүнээс харахад хувьцаа эзэмшигч нь тухайн компани орлого ашигтай байх үгүйгээс шалтгаалан их ашиг олж болох бөгөөд сөргөөр мөн их алдагдлыг хүлээж болно. Хувьцаа эзэмших нь банкинд мөнгөө хадгалуулснаас илүү ашиг өгч болно.

Хэрвээ хувьцаа эзэмшигч нь эрсдэл багатай банкинд мөнгөө хадгалуулах зэргээс олох ашгаас илүүтэйгээр хувьцаанаас ашиг олно гэж тооцвол энэ нь хараахан баталгаатай бус юм. Ерөнхийдөө бонд эзэмших, хадгаламжийн банкинд мөнгөө хадгалуулах зэргээс хувьцаа эзэмших нь илүү ашигтай байдаг. Хувьцаанаас олох ашиг урт удаан хугацааны хугацаанд дунджаар 10%-12% байдаг. Ганцхан удаагийн оролцоогоор хөрөнгийн биржээс ашиг олохгүй хэмээн брокерууд хөрөнгө оруулагч нарт зөвлөдөг. Урт удаан хугацааны турш дахь арилжааны үр дүнд хувьцаа эзэмшигч ашиг олдог. Хөрөнгө оруулагчид гарах ашиг, эрсдэл хоёуланг нь урьдаас тооцоолсон байх нь чухал.

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ Энэ бол таны маш чухал эрх.

- Хувьцаа эзэмшигч хувьцааг нь эзэмшиж байгаа компанийнхаа жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцах
- Энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн нэр, оршин суугаа хаяг, эзэмшлийн хувьцааны тоо зэрэгтэй танилцах
- Хувьцааг нь эзэмшиж байгаа компанийнхаа нэмж гаргах хувьцааг энгийн хувьцаа эзэмшигч эн түрүүнд худалдан авах эрхтэй.

Эрдэнэс Тавантолгой ХК нэмж хувьцаа гаргахаар бол Та нэмж гаргаж байгаа хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигчийн худалдан авч болох тоо, төлбөр хийх хугацаа зэргийг мэдэх эрхтэй.

Компани энэ талаар танд мэдэгдэх уурэгтэй. Та энэ эрхийнхээ дагуу хувьцаа худалдан авахын тулд мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор саналаа явуулна. Ингэхдээ өөрийн нэр, оршин суугаа хаяг, худалдан авах хувьцааны тоо, үнийг нь төлсөн баримтаа компанид өгснөөр Та хувьцааг худалдан авсанд тооцогдоно. Энэ эрхээ бусдад шилжүүлж болно.

Зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцааг нэн тэргүүнд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болдог гэдгийг анхаараарай.

Хувьцааг нь эзэмшиж байгаа компани тань дүрмэндээ нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулж тэр нь таны эрх ашгийг хөндсөн мөн санал хураалтад нь оролцоогүй бол Та хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.

Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахаар болсон бол тухайн үеийн зах зээлийн үнийг баримтална.

Хувьцаа эзэмшигчдийн хурал, хурлын шийдвэрийн талаарх хуралд оролцоогүй, оролцсон боловч санал нийлээгүй хувьцаа эзэмшигч дараах үндэслэлээр шүүхэд болон Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй байдаг.

ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ

- Компанийн тухай хууль, журам, компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаагүй.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах шийдвэр гарснаас хойш хуралдах өдөр, газрыг өөрчилсөн, түүнийгээ мэдэгдээгүй.
- Хурлаар хэлэлцэхээс өөр асуудлыг хэлэлцсэн.
- Компанийн эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан бол хувьцаа эзэмшигч хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

ЭРХ АШИГ ТАНЬ ХӨНДӨГДСӨН ГЭЖ ҮЗВЭЛ ХААНА ХАНДАХ ВЭ?

Үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө шаардлагатай болон хөрөнгөө өсгөх сонирхолтой талууд мөн тэдгээрийн дунд мэргэжлийн зуучлагч байгууллагууд ажилладаг тухай Та мэддэг болсон.

Харин одоо хэрвээ хувьцаа эзэмшигч таны эрх ашиг ямар нэг байдлаар хөндөгдвөл хаана хандах вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдана.

Манай улсад хөрөнгө оруулагч таны эрх ашгийг хамгаалдаг байгууллага нь анх "Үнэт цаасны хууль" 1994 онд батлагдан гарснаас хойш 2 сарын дараа Үнэт цаасны хороо нэртэй байгуулагдаж байсан бөгөөд 2006 оноос хойш Санхүүгийн зохицуулах хороо нэртэй ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн дагуу санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч талын эрх ашгийг хамгаалах гэсэн үндсэн үүрэгтэй ажилладаг бөгөөд үүнд үнэт цаасны зах зээлч үүнд багтдаг.

Та үнэт цаасны зах зээлтэй холбоотой аливаа маргаантай асуудлаар энэхүү төрийн байгууллагад хандаж болно.

Эрдэнэс Тавантолгойн хувьцааг иргэдэд үнэгүй эзэмшүүлэхтэй холбоотойгоор иргэд үнэт цаасны зах зээлийг сонирхох нь нэмэгдсэний зэрэгцээ цэнхэр, ягаан тасалбарын асуудлаар сүүлийн үед уг байгууллагад хандах иргэдийн тоо олширч байна.



ТА ХУВЬЦААНЫ
ДАНСАА НЭЭЛГЭСЭН ҮҮ?

ХУВЬЦААНЫ
ЦАГААН ТОЛГОЙ